


**ГАН ХИЙЦ ХК**

**КОМПАНИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН**



**2018.04 сар**


## НЭГ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР


2017 онд “Ганхийц” ХК – ний төмөр хийцийн үйлдвэр нь захиалгат ажлаар тасраагүй. 2017 оны борлуулалтын орлого нь 1,626 тэрбум төгрөг, захиалгат ажлуудын нийт төмөр хийцийн жин 240 тонн үйлдвэрлэсэн байна. Энэ нь өмнөх жилүүдтэй харьцуулахад дундаж үзүүлэлт харагдаж байна.

Ган хийц ХК-ийн 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг 94134400 төгрөг, ЗАА зардлын төсвийг 955428949 төгрөгөөр, борлуулалтын хэмжээг 4,75 тэрбум төгрөгөөр баталж өгсөн ба гүйцэтгэлээр дараах байдалтай байна.

№		Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Захиргаа , үйлчилгээний хэсгийн орон тоо, цалингийн сан	861 985 360	486 206 576,03	375 778 783.97
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн цалингийн сан	119 860 000	81 356 298.86	38 503 701.14



## 2015-2017 оны борлуулалтын орлого



Материал татан авалтыг боловсронгуй болгож, материал байнгын авдаг харилцагчтай болох. Өмнөх жилүүдэд томоохон ажлын материалыг Эрээн хотоос авдаг байсныг үргэлжлүүлэх болно.

2017 онд дараах томоохон ажилуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Захиалагч	Ажлын нэр	Хаана хийсэн	Хугацаа
Дорнод аймгийн ЗДТГ	Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын барилга	Дорнод аймаг	2013-2018
Боорчи ХХК	15x42 Дээврийн төмөр хийц	СБД 2-р хороо Усны гудамж 2А тоот	2017.05.08- 2017.05.30
“Суруга Монгол” ХХК	5С барилгын гол үүдний хэсгийн ган хийцтэй саравчийг үйлдвэрлэх	ХУД-ийн 15-р хороо Дөрвөн улирал цэцэрлэг	2017.05.04- 2017.05.12
“Эрдэнэбулган” ХХК	24м сэндвичин хүзүүвчний төмөр хийц	ЧД 2 хороо их тойруу 29 тоот	2017.05.23 ажлын 21 хоног

“Содон номин констракшн”ХХК	18х30м дээврийн төмөр хийц	БЗД 26 хороо баянмонгол хороолол 416-172 тоот	2017.07.05-2017.05.30
Төв аймгийн засаг даргын тамгын газар	36х20 спорт заал	Төв аймгийн аргалант сум	2017.04.01-2017.07.07
“ЭМ ЭН ПИ” ХХК	Төмөр хийц үйлдвэрлэх	БГД 2 хороо үндсэн хуулийн гудамж-24	2017.07.10 ажлын 10 хоног

2017 онд төлсөн татварын тооцоо		
№	Татварын нэрс	Төлсөн дүн
1	НДШимтгэл	67,000,000.00
2	ХАОАТ	26,000,000.00
3	ҮХЭХАТатвар	5,791,980.00
4	НӨАТ	100,000.00
5	Тээврийн хэрэгсэл	1,035,200.00
6	Газрын татвар	2,150,192.00
Нийт дүн		<b>102,077,372.00</b>

*УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ*

**Компанийн удирдлага бүтэц бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт**

2017 оны ТУЗ-ийн хурлаар Гүйцэтгэх захирлаар Ц.Батбаярыг томилсон. 2017 оны 11-р сарын 14-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар өөрийн хүсэлтийн дагуу ажлаас чөлөөлсөн.

**ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 13 тогтоол шийдвэр гарсан бөгөөд үүнээс 4 тогтоол нь ТУЗ-ийн гишүүдийн хуралаар хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь хуралдаа тогтмол оролцож, санал хүсэлтээ илэрхийлж байсан.

ТУЗ-ийн Хараат бус гишүүн П.Төвсанаа нь Дундговь аймгийн Аудитын хорооны даргаар томилогдсон тул ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ илэрхийлж, ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэсэн.

ТУЗ-ийн аудитын хорооны гишүүн Э.Долгорсүрэн нь санхүүгийн албанд хоёр удаа ирж шалгалт хийж, зөвлөгөө өгч ажилласан бөгөөд шалгалтын дүнг ТУЗ-ийн хуралд танилцуулсан.



### **Орон тоо бүтцийн талаар:**

ТУЗ-ын хурлаар баталсан ЗАА-н орон тооны бүтцийн дагуу зохих хүмүүсийг авч ажиллуулсан ба зарим нэг орон тоон дээр хавсран ажиллаж байлаа. Цаашид орон тооны дагуу хүмүүсийг авч ажиллуулах, шаардлага хангасан мэргэжилтнүүдийг авч ажиллуулахад анхаарах нь зүйтэй гэж бодож байна.

2017 оны ТУЗ болон Захиргаа, үйлчилгээний хэсгийн орон тоо цалингийн төсвийн гүйцэтгэл дараах байдалтай байна энэ хэмнэлт нь хэд хэдэн орон тоо сул байсан бөгөөд эдийн засгийн хямралтай үед өөрсдийн ажиллах хүчинээ нэмэхгүйгээр байгаа хүмүүсээрээ ажилласан болно.

№		Төсөв	Гүйцэтгэл
1	Зархигаа, үйлчилгээний хэсгийн орон тоо, цалингийн сан	330 825 600	238 564 880
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн цалингийн зардал	49 200 000	37 742 615

Компанийн мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс веб сайт шинэчлэгдэж, Хувьцаа эзэмшигчдэд зориулан булан гаргасан бөгөөд компанийн холбогдолтой бүхий л мэдээллийг авах боломжтой юм.



### **Шагнал тэтгэмж, тусламж**

2017 онд байгууллагынхаа 30 жилийн ойн хүрээнд ажилчид болон оршин байгаа нутаг дэвсгэрийнхээ байгууллага, ард иргэдэд харамгүй дэмжлэг туслалцаа үзүүлсээр ирсэн. Мөн Төрийн дээд болон салбарын шагналаар шагнагдаж байна.

1. Компанийн өндөр настан ахмадууд, гарын бэлэг гардуулж, компанийн үйл ажиллагаатай танилцуулсан. Үүнд 3 602 000 төгрөгийн зарцуулсан байна.
2. Компанийн Ерөнхий инженер Б.Ганбат, Барилга хариуцсан захирал Ц.Пүрэвжаргал нар нь Тэргүүний барилгачин цол тэмдгээр шагнагдсан, Мөн Санхүүгийн албаны нягтлан бодогч Л.Болор-эндэнэ Сангийн яамны жуух бичгээр, Хүний нөөцийн менежер О.Ууганцэцэг нь Хөдөлмөрийн яамны Тэргүүний ажилтнаар тус тус шагнагдаж, шагналд 636000 төгрөгийг зарцуулсан байна.
3. Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр болон шинэ жилийн баярыг тохиолдуулан компанийн ажилчдын хүүхдүүдэд бэлэг дурсгалын зүйл гардуулсан. Үүнд 1390000 төгрөгийг зарцуулсан байна.
4. Нийгмийн даатгалын салбар үүсч хөгжсөний 75 жилийн ойг тохиолдуулан 200000 төгрөгийн шагнал олгосон.
5. Ардын хувьсгалын 95 жилийн ойн арга хэмжээг угтан Б.Галсанжамц, Д.Өлзийбаяр нарын МУ-ын Хөдөлмөрийн хүндэт медаль, О.Очирыг Осолгүй манлай жолооч, Б.Мөнхбат, П.Ариунаа, Ч.Мядагмаа, Ч.Төрмөнх нарыг Тэргүүний барилгачин цол тэмдгээр, Н.Түмэнбаяр, Ж.Уранбилэг, Н.Батхишиг, Д.Цэдэнбал нарыг Хүндэт жуух бичгээр шагнаж, урамшуулсан.

#### ХОЁР. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

#### **Компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ**

Ган хийц ХК-ний 2017 оны 12 сарын 31 ны өдрөөрх санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн Санхүүгийн байдлын тайлан (СТ-1А), Орлого үр дүнгийн тайлан (СТ-2А), Мөнгөн гүйлгээний тайлан (СТ-3А), Өмчийн өөрчлөлтийн тайлан (СТ-4А), санхүүгийн тайлангийн тодруулга (ТБСТТ-1-12)-аар гаргалаа.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн санхүүгийн мэдээллийг боловсруулах “MacS” санхүүгийн программыг ашиглаж байна.

Манай компани 2017 оны санхүүгийн тайланд “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК аудит хийж аудитын дүгнэлт, зөвлөмжийг өгсөн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн хурлаар 2017 оны санхүүгийн тайланг хэлэлцэж, 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар санхүүгийн тайланд залруулга хийхээр шийдвэрлэсэн.

#### **Жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа гаргасан тухай мэдээлэл**

- 2014 онд төрөөс 2,5 тэрбум зээл авч, тэр ондоо сар бүр зуун сая төгрөгний зээлийн эргэн төлөлт хийсэн ба нийтдээ 2014 онд зөвхөн хүү 104'060'620 төгрөг, зээлийн

эргэн төлөлтөнд 833'333'333 төгрөг төлсөн. 2015 онд зээлийн хүү төлөлт 108 сая төгрөг ба нийт зээлийн үлдэгдэл 1,4 тэрбум төгрөг болсон.

- Хас банкнаас авсан зээлийн асуудал нь маргаантай байгаа ба шүүх эцэслэн шийдвэрлээгүй болно.

## ГУРАВ.НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### **4.1. Компанийн тухай жилд тараасан ногдол ашгийн хэмжээ, тарааж буй хэлбэр, хугацаа болон ногдол ашиг тараагаагүй тохиолдолд түүний үндэслэл шалтгааны талаарх мэдээлэл**

- 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар нэгж хувьцаанд 100 төгрөг тараахаар шийдвэрлэсэн.
- 2017 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн тархалтын судалгаагаар нийт 123 хувьцаа эзэмшигч байсан.
- Үүнээс 2017 оны 08 сарын 31-ны өдөр 101 хувьцаа эзэмшигчдийн дансанд 1'236'150 төгрөгийг байршуулсан.
- Үлдсэн хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг компани дээрээ тараахаар шийдвэрлэсэн.

2018 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар нэгж хувьцаанд 100 төгрөг тараахаар шийдвэрлэсэн.

Уг шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулна.

